

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-06

Улаанбаатар хот

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон ХасБанк ХК-ийн хооронд байгуулсан  
Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") болон ХасБанк ХК ("ХасБанк")-ийн хооронд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээний 8 дугаар зүйлийн 8.6(b) дахь заалтад үндэслэн, ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТСН нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг ("**Хуулийн шаардлага**");
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид SR-2024-09 тоот тогтоол гаргаж, энэхүү Хуулийн шаардлагыг хангахдаа ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпорацийтай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд ТСН-ийг ХасБанкинд нэгтгэж, Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн ("**Нэгтгэх урьдчилсан нөхцөл**"), нэгдлийн үр дүнд ХасБанк үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох нь зүйтэй гэж үзсэн болохыг ("**Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах**");
3. ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь SR-2024-07 болон SR-2024-08 тоот тогтоолоор Нэгтгэх урьдчилсан нөхцөлийг биелүүлэхээр шийдвэрлэсэн болохыг;
4. Нэгтгэх урьдчилсан нөхцөл хангагдаж, ТСН болон ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсний дараа 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ТСН болон ХасБанкны хооронд Нэгтгэх гэрээг байгуулж холбогдох зөвшөөрөл авахаар Монголбанкинд хүргүүлсэн болохыг;
5. Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт гаргасан хувьцааны 20.39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болох МАК Инвест Кэй Эф Ти-д бий болсон өөрчлөлт нь түүний хувьцаа эзэмшигчдийн бүтцэд Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээг бий болгосон ба МАК Инвест Кэй Эф Ти нь ТСН дэх өөрийн эзэмшлийн хувьцааг шинээр үүсгэн байгуулагдсан, нэг эцсийн өмчлөгч хасагдсанаас бусдаар эцсийн өмчлөгчийн бүтэц ижил төсөөтэй бие даасан компани болох МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди ("**МАК Инвест Эс Жи**")-д шилжүүлэх замаар Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэхээр шийдвэрлэсэн болохыг ("**ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлт**");

6. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтөд холбогдуулан, ТСН-ийн саналын эрх бүхий хувьцааны 20.39%-ийг эзэмших шууд хувьцаа эзэмшигчээр МАК Инвест Эс Жи-г хүлээн зөвшөөрөхөөр SGR-2025-01 тоот тогтоолоор баталсан болохыг; мөн
7. ХасБанк болон ТСН-ийн хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтийг тусгаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг харгалзан, Хувьцаа эзэмшигчид нь Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-10 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

1. ТСН болон ХасБанкны хооронд байгуулах Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
2. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээтэй холбогдуулан, Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилготой “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам”-д оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
3. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтын дагуу шаардлагатай бусад холбогдох баримт бичгийн хамт ХасБанкны нэрийн өмнөөс үйлдэх эрхийг ХасБанкны Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав (“Эрх бүхий этгээд”)-д олгож, тийнхүү үйлдэхийг даалгасугай.
4. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг үйлдсэний дараа энэхүү гэрээ болон түүнд холбогдох бүхий л баримт бичгийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу ХасБанкны нэрийн өмнөөс хүргүүлж, бүртгүүлэхийг Өөрчлөн байгуулах комиссын гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА